

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 10 өдөр

Дугаар 26/17

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 60 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 67.1, 67.5, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 сарын 14-ны өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Бодь даатгал ХК-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.12.5, 8.12.6, 8.12.7 дахь хэсгийг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 сарын 10-ны өдрийн ээлжит хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Бодь даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал /цаашид “Хурал/ гэх/-ыг 2026 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр 11:00 цагт “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн AGM веб суурьтай аппликейшныг ашиглан цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2026 оны 08 сарын 11-ний өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлсүгэй.
3. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан 2026 оны 08 сарын 13-ны өдрийн дотор нийтэд зарласугай. Хурлын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компани, арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан хоёр ба түүнээс дээш удаа мэдээлсүгэй.
4. Мэдээллийн давталтыг 2026 оны 08 сарын 28-ны өдөр хүртэлх хугацаанд хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан дахин зарласугай.
5. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 08 сарын 31-ний өдрөөр тогтоосугай.
6. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2026 оны 08 сарын 18-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлсүгэй.
7. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай.
Үүнд:
Хурал зохион байгуулах комиссын дарга: Гүйцэтгэх захирал А.Энхжаргал,

Гишүүд: Санхүү, эрсдэлийн удирдлагын газрын захирал
Б.Балсан, Үйл ажиллагааны газрын захирал Ж.Наранцэцэг,
Бизнес хөгжлийн газрын захирал М.Мөнхбаатар,
ТУЗ-н нарийн бичгийн дарга Ө.Батчимэг, Хуульч
Х.Сарангоо, О.Энхжин, Хэлтсийн захирал М.Даваадэлгэр

8. Хурлын зарын загвар, хэлэлцэх асуудлыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
9. Хурлын дэгийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
10. Хурлын танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар баталсугай.
11. Хурлын саналын хуудасны загварыг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.
12. Хурлын материалыг 2026 оны 08 сарын 18-ны өдөр брокер, диллерын компаниудад хүргүүлж, хувьцаа эзэмшигчдэд Хурлын материалтай ажлын өдрийн 10:00-17:00 цагийн хооронд ирж танилцах боломжийг бүрдүүлэхийг Гүйцэтгэх захирал болон Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
13. Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдэд саналаа урьдчилан өгөх боломжоор хангаж Би Ди Сек ҮЦК ХХК-ийн Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, төв байр хаягаар дамжуулан авах ба саналын хуудсыг авах сүүлийн хугацаа 2026 оны 09 сарын 18-ны өдрийн 15:00 цаг байна.
14. Хурлын даргаар Бодь даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал А.Энхжаргалыг томилсугай.
15. Хурлын тооллогын комиссын даргаар Хуульч Х.Сарангоо, гишүүд: Ж.Наранцэцэг, О.Энхжин, С.Дөлгөөн нарыг ажиллуулахыг зөвшөөрсүгэй.
16. Хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Хурлын дарга А.Энхжаргал болон Хурал зохион байгуулах комиссын гишүүн Бизнес хөгжлийн газрын захирал М.Мөнхбаатар нарт даалгасугай.
17. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох мэдээлэл, баримт бичгийг бэлтгэх ажлыг хийж гүйцэтгэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ө. Батчимэгт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.БИЛЭГТ